



Б.БАЯСГАЛАН
ХСИС-ийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн Харуул
хамгаалалтын
тэнхимийн эрхлэгч,
хурандаа

**ӨНӨӨГИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ
БОДЛОГО, ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ТУЛГАМДСАН
АСУУДЛУУД ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН
ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА**

Түлхүүр үг: Эрх зүйн шинэтгэл, хорих ял, хорихоос өөр төрлийн ял, зорчих эрхийг хязгаарлах ял, нийгэмшүүлэх, нээлттэй хорих анги, хаалттай хорих анги.

Агуулга: Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулиар хорих ял эдлэгсдийн тоо төдийлөн буурахгүй байна. Хорих ял эдлэгсэдэд үзүүлэх нийгэмшүүлэх ажлыг үр нөлөө хангалттай биш, хорих ял эдлэгсдийг шоронжуулж байгаа, хорих ял нь нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавартай болохыг эрдэмтэн судлаачид нотлож байгаа билээ. Иймд эрх зүйн шинэтгэл хийх ажлын хүрээнд аль болох хорих ялаас татгааж хорихоос өөр төрлийн ялыг манай улс, орны хөрсөнд буулган хэрэгжүүлэх асуудлыг хөндөхийг оролдсон билээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тулгамдсан асуудлын нэг бол хорих ялаар шийтгэгдсэн хоригдолын тоо байсаар ирсэн.

Сүүлийн арван жилд жилд дунджаар 6000-7000 хүн хорих ялыг биечлэн эдэлж байгаа ба 2002 оны Эрүүгийн хууль үйлчилж буй тохиолдолд хорих ангид ял эдлэж буй хүний тоо буурах шинжгүй.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зааснаар ялын бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголттой болгох зорилт дэвшүүлж хорих ангийн төрөл дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх болсон билээ.

Хорих ял гэдэг нь ялтныг олон нийтээс тусгаарлаж харуул хамгаалалт хяналт бүхий хорих тусгай байгууллагад байлгахад оршино¹ гэдэг нь дараах үйл ажиллагааг зохицуулах тэдгээр хорих ял эдлэгсдийг байрлуулах, хооллох, хувцаслах, хүмүүжүүлэх гэх мэт асуудлуудаас хамгийн түвэгтэй асуудал нь ажлын байр, хөдөлмөрийн зах зээлээр хангах явдал, үүнийг төр зохих ёсоор шийдвэрлэж чадаагүй ирсэн одоо ч зохицуулахад бэрхшээлтэй асуудал нэг байсаар байна.

Үүний дараа хоригдлыг хүмүүжүүлэх асуудал чухал асуудал болсон бөгөөд төр засгийн байгууллагууд хоригдлыг хүмүүжүүлнэ, дахин хүмүүжүүлнэ гэж хууль дүрмэндээ зааж хүмүүжүүлэгч гэдэг албан тушаалтан

¹ Ж.Амарсанаа, Г.Баясгалан, Ж.Бямбаа, Т.Мөнхжаргал, С.Нарангэрэл, Г.Совд, Г.Уранцэцэг. Хууль зүйн тайлбар толь. УБ хот 2003 он тал 297

ажиллуулж ирсэн боловч хоригдолд хүмүүжил олгох боломжгүй болох нь харагдаж байгаа билээ. Тийм утгаараа сүүлийн үед хүмүүжил гэдэг нэр томъёоноос татгалзан хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлнэ хэмээж нийгмийн ажилтан ажиллуулаж цол хэргэм, албан тушаалыг нь ахиулсан боловч төдий л ахиц дэвшил гараагүй л байна. Хорих байгууллагад хоригдох хүний тоо улс төрчдын анхаарлыг татаж ирсэн бөгөөд 2002 оны Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулиуд шинээр батлагдахад тухайн үед хорих ял эдлэгсдийн тоо 6000 гаруй болж байсныг үлэмж хэмжээгээр цөөрнө гэж үзэж байлаа гэтэл 2015 оны байдлаар хорих ял, баривчлах ял эдлэгсдийн тоо цөөрсөнгүй харин улам нэмэгдсэнийг дээр дурьдсан билээ. Хорих ял эдлэгсдийн тоо өсөх тусам улсын төсвөөс зарлагдах хөрөнгө, мөнгө улам өсөж үргүй зардал гарсаар байгаа нь хүн бүхэнд ил тод байна. Иймээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хорих ял эдлэгсдийн тоог цөөрүүлэх хорихоос бусад төрлийн ялыг өргөн ашиглах нь зүй ёсоор тавигдаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн шинэтгэл нь хууль зүйн шинжлэх ухааны салшгүй салбар эрх зүй мөн тул хууль зүйн шинжлэх ухааны хөгжил чиг хандлагатай хамаарал бүхий ойлголт мөн билээ. Хууль зүйн шинжлэх ухааны хөгжил чиг хандлага нийгэм, эдийн засгийн хөгжилтэй шууд холбоотой байдаг тул шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйг түүнээс салган ойлгох аргагүй билээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх

эрх зүй нь тухайн нийгмийн хөгжлөөс хамаарч нийгмийн өмнө тавьсан шаардлагыг гүйцэлдүүлэхийн тулд шинэчлэгдэн хөгжиж ирсэн тодорхой байна. “Эрх зүйн хүрээний өөрчлөлт, шинэтгэлийн асуудал” бүтээлдээ доктор профессор Б. Чимэд эрх зүй нь ганцаараа агаарт дүүжлэгдсэн дэнлүү биш. Харин тухайн нийгмийнхээ ахуй, ухамсраар мөн чанар нь нөхцөлдөн тодорхойлогддог нийгмийн бүхий л харилцаатай шүтэлцсэн нарийн түвэгтэй үзэгдэл, бүхэл бүтэн тогтолцоо мөн билээ. Энэ тогтолцоо наандаж:

- Хууль ба түүнд нийцсэн эрх зүйн бусад хэм хэмжээ

- Үнэлэн цэгнэх нийгмийн эрх зүйн ухамсар

- Уул хэм хэмжээг ухамсарласны үндсэн дээр хэрэгжүүлэх нийгмийн практик гэсэн гурван хэсгээс бүрэлдэн тогтодог.

Үүнээс үзвэл эрх зүйн шинэтгэл нь хууль, тогтоол, дүрэм, зааврыг өнгөцхөн “нухаж” өөрчлөх, сайжруулах төдийхөн бус, харин ихээхэн цар хэмжээтэй үйлс мөн болно² гэсэн ба цар хүрээтэй үйлс гэдэг уг та бидний анхаарлын төв байвал зохино. Эрх зүй бол нийгмийн хөдөлгөгч дөрвөн зүйл улс төр, эдийн засаг, нийгэмшил, соёл-оюуны тохируулагч мөн тул эрх зүйн шинэтгэлийн асуудал хамгийн анхаарал татах зүй бизээ.

² Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи Философи, социологи, эрхийн хүрээлэн. Монголын нийгмийн өөрчлөлт. УБ хот. 2013 он. тал 320

Эрх зүйн шинэтгэлийн үндсэн чиглэлийг доктор, профессор Б.Чимэд дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

Нэгдүгээрт: *Хууль тогтоомжийг шинэтгэх.* Энэ бол уул шинэтгэлийн гол цөм мөн. Тэр нь бас хуулийн дэд актууд (Засгийн газар түүний байгууллагууд, нутгийн удирдах газруудын эрх зүйн хэм хэмжээний)-ыг шинэ хуулиуудад нийцүүлэн өөрчлөх нөр их ажлыг дагалдуулдаг.

Хоёрдугаарт: *Хууль тогтоох, хуулийн гүйцэтгэлийг хангах, хууль хэрэглэх тогтолцоо, арга ажиллагааг шинэтгэх.* Энэ бол парламент, гүйцэтгэх хийгээд шүүх эрх мэдлийн бүх төрөл, бүх шатны байгууллагын чиг үүргийн хуваарилалт, хариуцлага, хуульд хандах зарчим, хэлбэр, арга барил, эв дүйг хүртэл (тэнд буй хүмүүсийг) шинэтгэх түвэгтэй ажил мөн.

Ялангуяа эдгээр үйл ажиллагааны эрх зүйн дэг журмыг нарийсгаж, хууль дээдлэх ёсыг дээрээсээ дэндүү сайн сахих нь амин чухал. Энэ бол шинэтгэлийн сайхь чиглэлийн гол агуулга мөн. **Шинэ хуулийг шинэчлэгдсэн парламент зөв бүтээж, дуулгаваржсан захиргаа ёсчлон биелүүлж, цэвэржсэн шүүх шударгаар хэрэглэж чадна.** Энд хүн ба хуулийг дээдлэх ёс онцгой анхаарал татна.

Гуравдугаарт: *Хууль зүйн мэргэжлийн боловсролыг шинэтгэх.* Шинтгэл гэдэг бол угтаа машин техник, барилга байшин солих, шинээр сүндэрлүүлэх ажиллагаа биш. Ингэж харагдаж, тэгж илэрдэг боловч язгуураас нь авч

үзвэл хүнийг шинэтгэх, хүн өөрийгөө өөрчлөх асуудал мөн. Эрх зүйн шинэтгэлийн эцсийн дүнд хүн, юуны өмнө хууль тогтоогчид, гүйцэтгэгч, хэрэглэгч, эрх зүйн мэргэжилтэй боловсон хүчин хийнэ.

Дөрөвдүгээрт: *Хууль зүйн эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйг шинэтгэх.* Энэ бол хүн төрөлхтний хувьд ууган боловч Монголын хувьд хамгийн залуу шинжлэх ухаан мөн. Энэ салбарыг дан ганц марксист онол, арга зүй, ангич хандлагаас ангижруулж, хүн төрөлхтний эрх зүйн мэдлэг соёлын суурь дээр Монголоо судалж, мэдэж хөгжүүлэх, хэрэгцээнд үндэслэн жинхэн ёсоор хөгжүүлэх хүндхэн зорилт юм.

Тавдугаарт: *Нийгэмд эрх зүйн шинэ ухамсар төлөвшүүлж, сайн эрх зүйг үгүйсгэхтэй тэмцэх.* Энэ бол өгүүлэн буй шинэтгэлийн хамгийн түвэгтэй “үл үзэгдэх” урт хугацааны зорилт бөгөөд бодитой үнэлэж, зөв тайлж, онож хийвэл зохих үзэл онол, мэдрэмж шаардсан ажил юм. Гажуудлын тусгал болсон хуучин ухамсар хийгээд шударга хуулийг үгүйсгэх орчин цагийн сөрөг үзлийг таягдан хаяхын зэрэгцээгээр нийгэмд эрх зүйн шинэчлэгдсэн сэтгэл зүй, шинэ үзэл онолыг бүрдүүлэх ажлыг төрийн зүгээс чиглэсэн зорилготой хийх нь уул ажлын үндсэн агуулга мөн.

Дээр дурдсан таван чиглэлийг эрх зүйн шинэтгэлийн нарийн ширийн хийгээд нийгмийн харилцааны бүх салбарт хамаарах бүх шижмийг багтаасан гэдэг санаагаар ангилсангүй. Харин уг үзэгдлийг бүрдүүлэгч үндсэн

элементийг хамаарна гэж үзэж болно³ гэсэн байдаг. Тэгвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн шинэтгэлийг дээрх таван зүйлтэй уяалдуулан холбож явуулах хэрэгтэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ардчилсан хувьсгалын 25 жилийн ойн баярын хурал дээр “Ардчилсан хөдөлгөөнөөр бид эрх, эрх чөлөөгөө эргүүлэн олж авсан. Бид Монгол Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг олж авсан юм. Ардчилал бол хүрэх зогсоол биш, үл төгсөх үйл явц. Нэг асуудлыг шийдвэрлэхэд дараагийн асуудлын хариуг нэхэж байдаг”⁴ гэдэгтэй адил эрх зүйн шинэтгэл бол эцэс төгсгөлгүй байнга хөгжин төгөлдөржиж байдаг эрх зүйн процесс мөн.

Манай орны эрх зүйн шинэтгэлийн чиг хандлага Ром-Германы эрх зүйн бүл соёл, түүний хөгжил чиг хандлагатай салшгүй холбоотой тул эх газрын эрх бүл бүхий орнуудын шүүхийн шийдвэр гүйцэтгэх буюу хорих байгууллагуудын үйл ажиллагаатай судалгаанд түшиглэн товчхон боловч танилцуулья.

Жишээ болгон барууны зарим нэг орны хорих байгууллагуудын талаар уншиж судалсан, үзэж харсан судалгаанд тулгуурлан, өөрийн санаа бодлоо тольдуулья.

³ Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи Философи, социологи, эрхийн хүрээлэн. Монголын нийгмийн өөрчлөлт. УБ хот. 2013 он. тал 322-333

⁴ К.Чулуунбаатар, Д.Баатар, Ц.Хажидмаа, Ц.Жамц, Г.Бадамханд Эрх зүй, төрийн үндэс. УБ хот 2015 он тал 111

ХБНГУ-ын хорих байгууллагын хорих ял эдлүүлэх дэглэм нь нээлттэй буюу хаалттай гэсэн хоёр хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг.

Нээлттэй хорих ангид 6 сар хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгүүлэгсэд эсвэл нийгмийн хор аюул багатай гэмт хэрэг үйлдэгсдийн ялыг эдлүүлдэг энэхүү ял эдлэгсэд нь харьцангуй эрх чөлөөтэй байж үйлдвэр хөдөө аж ахуйн байгууллагууд гэрээгээр хөдөлмөр эрхлэж, ажлын цаг дууссаны дараа оройн хооллоо бие даан зохицуулаад хорих байрандаа ирж ирцээ танилцуулан амардаг ба өглөө нь жирийн ажилчид шиг олон нийтийн болон хувийн машин тэргээ хөлөглөн явж ажил хөдөлмөрөө хийдэг нь манайхаар бол нийтийн байранд амьдарч буй хүмүүстэй адилхан байдаг. Энэхүү зохицуулалт нь ЗХХ байгууллагад 1980 оны эхэн үед МАХН-ны Улс төрийн товчооны 206 тоот тогтоолоор “тусгай комендатур”-ыг байгуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохыг даалгасан байдаг. Тусгай комендатурыг үүрэг зорилго нь болгоомжгүй гэмт хэрэг үйлдэж тав хүртэл жил, санаатай боловч нийгмийн хор аюул багатай гэмт хэрэг үйлдсэн 2 хүртэл жилийн хорих ялаар шийтгүүлсэн хорих ял эдлэгсэдэд оногдуулдаг нэг төрлийн хөдөлмөр хүмүүжлийн хэлбэртэй нээлттэй хорих анги, байгууллага байсан. Энэхүү тусгай комендатур нь Сэлэнгэ аймгийн Баруун Хараа САА буюу одоогийн Баянгол сум, Төмөр замын Толгойт өрөө, Налайх хотод тус тус байгуулагдан үүргээ гүйцэтгэж байсаныг өнөөгийн

нийгэм, эдийн засаг, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон хэрэгжүүлж болох талтай гэж бодож байна.

Хаалттай хорих ангид санаатайгаар хүнд гэмт хэрэг үйлдэж 6-15 жилийн хорих ялаар шийтгүүлсэн насанд хүрэгч этгээдүүдийг хорьж гэм буруугаа ухамсарлах боломж олгох зорилгийг агуулдаг байна. Хаалттай хорих ангид хоригдогсод тухайн хорих байгууллагын нутаг дэвсгэр, үйлдвэрийн талбайд хүний эрх, эрх чөлөөг харьцангуй чөлөөтэй эдэлдэгээс гадна манай хорих ангиудад хэрэгжүүлдэг цэрэгжисэн зохион байгуулалтгүй ял эдлэгсэд хорих ангийн удирдлага албан хаагчидтай ердийн харилцаатай байдаг онцлогтой. Хоригдол ч гэсэн энэ нь хүний жам ёсны эрх, эрх чөлөө, үндсэн хуульд заасан эрхийг аль болох эдлүүлэхийг эрмэлздэг байдал ажиглагдаж байсныг тэмдэглэх хэрэгтэй гэж үзлээ.

Судалгаанаас үзэхэд барууны хөгжилтэй орнууд түүний дотор Шведын хууль цаазны байгуулага хорих ял эдлэгсэдийг аль болох өөрийгхөө авьяас чадварыг нээх гар урлал, уран зураг зурах, баримал цутгамал хийхэд нь хорих байгууллагын ажилтан онол арга зүйн зөвлөлгөө өгч эд материалын тусламж үзүүлэн дэмжин тусалдагаараа хорих ял эдлэгчдийг завгүй байлгах бодлого барьж ажиглагддаг. Анх удаа, нийгмийн хор аюул багатай гэмт хэрэг үйлдсэн этгээдэд амралтын өдрүүдэд чөлөө өгч тодорхой заасан хот дүүргээр явж нийгмийн амьдралтай танилцах

боломж олгож нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулж хорих байгууллагаас суллах сэтгэл зүйн бэлтгэлд хамруулдаг жишээ байна.

Мөн түүнчлэн хорих ял эдлээд суллагдахад нь уг этгээдийг нийгэмшүүлэх ажлыг гүнзгийрүүлэн зохион байгуулан уг этгээдийг засарал хүмүүжил баттай олсон нийгмийн дунд бие зөв боловсон авч явах чадвартай гэж үзвэл дахин хууль зөрчвөл хүлээлгэх хариуцлагыг сануулан гэр орон, эхнэр хүүхэдтэйгээ амьдарч ажил хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрдөг. Суллагдсан этгээдийн хойноос нийгмийн ажилтан байнга анхаарал хандуулан зарим үе гэр бүлийн гишүүд, хүүхэдээс тухайг этгээд хэрхэн амьдарч байгаа, гэр бүл хөршийнхөндөө хүндэрэл учруулж байгаа эсэх талаар судалдаг. Хэрэв уг этгээд хууль дүрэм зөрчвөл хуулийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт үйлчилдэг. Энэхүү эрх зүйн хэм хэмжээг манай орны нөхцөлд тохируулан хэрэгжүүлж болох юм шиг санагдсан.

Үүний зэрэгцээ хууль, эрх зүй судлаач нарын анхаарлыг татаад байгаа “зорчих эрхийг нь хязгаарлах” ялыг ялын төрөлд багтаан хэрэгжүүлэх боломжийг тал талаас нь бодолцох хэрэгтэй. Энэхүү төрлийн ялыг эдлүүлэхэд анхаарал татсан асуудлууд олон байна. Жишээ нь хорих ял эдлэгсэдийг зорчих эрхийг нь хязгаарлах ялыг хэрхэн эдлүүлэх, тухай ял эдлэгчийн ар тал, гэр бүлийн байдал, эдийн засгийн чадвах, чадамж тухайн хүний ёс суртахуун, хүмүүжил, харилцааны түвшил нөлөөлөх нь гарцаагүй. Мөн

түүнчлэн орчин үеийн цахим техник техинолгийн шийдэл голлох нөлөөлөл үзүүлэх нь ойлгомжтой.

Зорчих эрхийг нь хязгаарлах шинэ ялын төрөл, хугацаа нь 1 сараас 5 жил хүртэл байхаар төсөлд тусгасан ба шүүх, хууль сахиулах байгууллагаас тогтоосон замаар явж тодорхой тооны хүмүүстэй харьцахаас гадна оршин суугаа газраа өөрчлөхгүй байх ёстой. Хэрэв шүүхийн шийдвэрийг үл хэрэгжүүлсэн тохиолдолд нийгэм, хамт олны дунд явж ажил үүрэг гүйцэтгэх, зарим нэг хүмүүстэй харьцахыг нь хориглохоор тусгасан байна. Зорчих эрхийг нь хязгаарлах ялаар шийтгэгдсэн этгээдэд электрон гав бугуйвчийн тусламжтайгаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавих ажээ.

Манай улс зах зээлийн эдийн засгийн системд эргэлт буцалтгүй шиджиж Үндсэн хуулиар шударгаар хувийн өмчтэй болохыг хуульчилсан ба хувийн өмчийг хамгаалахаар заасан ба сүүлийн 20 жилд хувийн өмчтөн үндэсний тэрбумтнууд төрсөн нийт хүн амын 10-ад хувийг эзлэж тэдгээрийн хөрөнгө үндэсний баялагын 90 гаруй хувийг эзэмшиж байна гэсэн судлагаа байдаг. Сүүлийн жилүүдэд төрийн болон төсвийн мөнгө, өмч хөрөнгө завшихаас улбаалан гэмт хэрэгт холбогдох, улс төрийн болон захиргааны албан тушаалтнуудаас /цагаан захтанууд/ авилгал, хээл хахуулийн гэмт хэрэгт холбогдох нь ихсэж байна. Энэ төрлийн гэмт хэргийг хэрэг гэж тооцох ч байж нийгмийн нэгэн үзэгдэл хэмээх үзэх хандлага ажиглагдах боллоо.

Сүүлийн үед хорих ял эдэлж буй ялтан өөрийн зардлаар дээд боловсрол эзэмшиж ял эдэлж байх хугацаандаа өндөр насны болон бусад тэтгвэр, тэтгэмж тогтоолгох эрхийг нэмэх санал оруулж байгаатай холбогдуулан дараах зүйлд шүүмжлэлтэй хандаж байна.

Гэмт хэргийн өрнөлт түүний чиг хандлагыг харахад улс төрийн болон төрийн албан тушаалтанд зориулсан хорих байр, эмнэлэг байгуулан тэдгээр гэм буруутай этгээдүүдийн хувийн зардлаар хангалт үйлчилгээ үзүүлдэг болоод байгаа нь олон нийт харж байна.

Үүнд: *“эрх зүй ямагт шударга байдаг бол хууль шударга бус гардаг”* талаар Ромын үеийн эрдэмтэн мэргэд сургасан байдаг. Өнөөгийн монголын нийгэмд хуулийг хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашигт нийцүүлэн гаргах түүгээр үл барам зарим нөлөө бүхий улс төрчид ирээдүйд болох эрүүгийн нөхцөл байдал тохируулан хууль боловсоруулах, зарим нэгэн нь залуу хуульч, эрх зүйч нарыг ивээлдэх авах, төрийн зарим албан тушаалд томилох үзэгдэл гаргаж байгааг яагаад ч хүлээн зөвшөөрхөөргүй үйл явц, ажиглагдаж байгааг одооноос засаж залруулах хэрэгтэй байна.

Үүний зэрэгцээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн уучлал үзүүлэх эрхийг хасах хэрэгтэй гэж өнгөрсөн үйл явцаас дүгнэж болмоор байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн нь нийгмийн харилцааг зохицуулж ирсэн түүхэн уламжлал өнөөгийн нийгмийн өөрчлөлт хууль зүйн шинжлэх ухааны шинэчлэл, эрх зүйн хөгжилтэй шууд холбоотой

болох нь харагдаж байна. Энэхүү өгүүлэлдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн шинжлэх ухааныг өнөөгийн нийгэмтэй холбон тулгамдаж байгаа асуудлыг чадлынхаа хөндөхийг хичээсэн билээ. Үүнээс улбаалан дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монголчууд нүүдлийн соёл иргэншлийн үед цаазар авах ял зонхилон хэрэглэж байсан нь эх сурвалжаас тодорхой энэхүү ялын төрлийг өнөө үед үргэлжлүүлэн хэрэглэх нь онц аюултай гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг ядаж айлган сүрдүүлэх эрх зүйн зохицуулалт байх шаардлагатай гэж үзээд цаазын ялгүй орон болох асуудлыг түдгэлзүүлэх хэрэгтэй байна.

2. Хорих ялыг манай оронд XIX-XX зууны үеэс хэрэглэх болсон нь Европын суурин иргэншлийн нөлөө эх газрын эрх зүйн бүлийн харилцаа нэвтэрсэнтэй шууд холбоотой гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Иймээс энэхүү ялын төрлийг аль болох бага оногдуулах шаардлага өнөөгийн нийгэмд үүсээд байна.

3. Эрүүгийн эрх зүй хэм хэмжээ, түүний харилцаатай холбоотойгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн зохицуулалтанд өөрчлөлт орж аймаг нийслэлд хорих анги бий болгож байгаа нь цаашид хорих ялыг өргөн хэрэглэх бодлого ажиглагдаж байна. Үүнээс татгалзах.

4. Дэлхийн дахины шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн шинжлэх ухааны дэвшилтэт чиг хандлагыг Монгол орны нөхцөлд тохируулан хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэх, шинэ ялын

төрлийг зоригтойгоор буй болгох шаардлага байгааг хууль санаачилагчид болон хууль тогтоох байгууллагад хүргэх нь зүйтэй гэж үзлээ.